



Дэлхийн тамхигүй өдрийг тэмдэглэж байна.



ДОХ-той тэмцэх дэлхийн өдөр



Архины зохисгүй хэрэглээтэй тэмцэх өдөр



Дэлхийн зөн ОУБ-ын сахүүжилтээр 57-р сургууль дээр 90 үе тэнгийн сурагч бэлдсэн

Судалгаа /1999-2017/

Он	Хамрагдсан нийт хүн	Хэрэглэгчийн тоо	Нэмэгдсэн тоо	Байнга Хэрэглэгч	Хааяа хэрэглэгч	Нэг удаа хэрэглэсэн
1999	1000	45		4	13	28
2000	3000	52		6	18	28
2001	5000	140	88	11	59	70
2002	1000	170	30	25	75	70
2003	1500	223	43	41	82	100
2004	840	283	60	56	95	132
2005	1000	320	37	61	101	158
2006	1000	410	90	80	120	120
2010	2000	464	54	54	-	-
2012	100 МБХ	561	47	100	-	-
2014	80 МБХ	570	9	109	-	-
2016	1000	620	50			

ХАР ТАМХИ МАНСУУРУУЛАХ БОДИСООС ИРГЭДИЙГ ХАМГААЛАХ НИЙГЭМЛЭГ



ТАНИЛЦУУЛГА

УЛААНБААТАР



Баянгол дүүрэг БГД-ийн 16 –р хороо "Баруда",
210 тоот, Шуудангийн хаяг: Улаанбаатар - 23, ш/х-88

Утас: 9919 9228, 99143669, 91399228, 91995293

Е-мэйл хаяг: shikhagvasuren2014@yahoo.com

ХАР ТАМХИ МАНСУУРУУЛАХ БОДИСООС ИРГЭДИЙГ ХАМГААЛАХ НИЙГЭМЛЭГ

Хар Тамхи Мансууруулах Бодисоос Иргэдийг Хамгаалах Нийгэмлэг нь (ХТМБИХН) 1999 онд байгуулагдсан 1022962 регистртэй ашгийн бус, шашны бус, нийгэмд үйлчилдэг, төрийн бус байгууллага юм.

Алсын хараа Нийгэмлэг нь нийгмийн сайн сайхны төлөө ард иргэдийг мансууруулах бодисын хороос урьдчилан сэргийлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмэр оруулах хүмүүнлэг ардчилсан эрх зүйт нийгмийг цогцлон бүрдүүлсэн хуультай болоход нөлөөлөх

ХТМБИХН-ийн зорилго

Архи, тамхи, мансууруулах бодисгүй эрүүл орчин бүрдүүлэх, ХДХВ/ДОХ/БЗДХ-оос урьдчилан сэргийлэх, мансууралгүй улс орон, ард иргэдтэй болох, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлж, хүмүүнлэг ардчилсан нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой.

Зорилт

Хар тамхи мансууруулах бодис хэрэглэгчдэд зан үйлийг өөрчлөх сургалт явуулж, сэтгэл зүйн зөвлөгөө өгч, хорт зуршилаас нь ангиржуулах

Иргэд, өсвөр үе, залуучуудад ХДХВ/ДОХ/БЗДХ-с урьдчилан сэргийлэх, мансууруулах бодисын хор хөнөөлийг ойлгуулах сургалт явуулж, ухуулга сурталчилгаа хийх

Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмэр оруулах хүмүүнлэг ардчилсан эрх зүйт нийгмийг цогцлон бүрдүүлсэн хуультай болоход нөлөөлөх Бусад байгууллагатай холбоо тогтоож тэдний туршлагаас суралцаж хамтран ажиллах.

Бүтэц: ХТМБИХНийгэмлэг нь удирдах зөвлөл, хянан шалгах зөвлөл, гүйцэтгэх алба гэсэн бүтэцтэй. Булган, Дорноговь, Өмнөговь, Хөвсгөл, Баянхонгор, Ховд, Сэлэнгэ, Дархан, Эрдэнэт хотуудад нийт 12 салбар зөвлөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна

Үйл ажиллагаа.

Сургалт-Үе тэнгийн сургагч бэлдэх
Сургагч багш бэлдэх
Зан үйлийг өөрчлөх
Сурталчилгаа-Мансууралтай тэмцэх дэлхийн өдөр

ДОХ-той тэмцэх дэлхийн өдөр
Тамхитай тэмцэх дэлхийн өдөр
Архитай тэмцэх дэлхийн өдөр

Судалгаа – жил бүр судалгаа хийдэг
СДЗШ-МБСТарьж хэрэглэгчдийн дунд хийдэг.
Сэтгэл зүйн зөвлөгөө-НА бүлгийн
Ганцаарчилсан
Гэрбүлийн

Сайн дурын клубийн үйл ажиллагаа
Зүү тариур соилцооны хөтөлбөр хэрэгжүүлдэг
Бэлгэвч олгох хөтөлбөр хэрэгжүүлж байна.
Шийдвэр гаргагчдын дунд нөлөөллийн уулзалт хийж ирсэн

Төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Японы ЭСЯ-ны “Өвсний Үндэс” хөтөлбөр, Монгол-Австралийн хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөр SAS, ДЭМБ-ын дэмжлэгээр PAF төсөл, НҮБ-ын UNODC санхүүжилтээр “Мансууруулах бодисгүй Монгол орон” нэртэй DAPC төсөл, ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төсөл,

НЭМГ, МОНЭС, Австралийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны САВ, SAF, ЭМЯ, ЭМДС, НИТХ, НГХУСАЗЗ, НЗДТГ, НҮБХАС, НҮЭМ-ТББ сүлжээ, АДРА ОУБ, МГБССНийгэмлэг”, Усан молор” ХХК, Дэлхийн зөн, ОУБ зэрэг байгууллагуудын санхүүжилтээр 40 гаруй төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн.

2014 оноос ЭМЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй “ХДХВ/ДОХ-оос сэргийлэх тусламж үйлчилгээ, дэмжлэгийн үндэсний хөтөлбөрийг өргөжүүлэх замаар ХДХВ-ийн халдварын тархалтыг бага түвшинд тогтоон барих” хөтөлбөрийн салбар хүлээн авагч болж, хар тамхи мансууруулах бодис хэрэглэгчдийн дунд ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, сурталчилгаа, хүрч очих үйл ажиллагаа явуулж байна. Мөн олон төрлийн гарын авлага, нугалбар ном, тараах материал хэвлэж нийтлүүлсэн.

Сурталчилгаа

Жил бүр “Мансууралтай тэмцэх Дэлхийн өдөр” тэмдэглэх болон бусад үйл ажиллагааг мансууруулах бодисын чиглэлээр бүх талуудын оролцоог ханган, ХТМБХэрэглэгчидтэй хамтран тэмдэглэдэг.

